

“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-Д 2001 ОНООС ХОЙШ ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖСЭН ТӨСЛҮҮД БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР АЖИЛЛАЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

Огноо:2023.01.11

Д/д	Төслийн нэр	Төслийн санхүүжилт	Зээлийн хэмжээ, зээлийн хүү	Зээл төлөлтийн хэмжээ (жил бүр) төгрөг	Зээл эргэн төлөгдөх хугацаа он	Төсөл хэрэгжсэн огноо	Төслөөр хэрэгжүүлсэн ажлууд, гарсан үр дүн
А. ХЭРЭГЖСЭН ТӨСЛҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА							
1	“Эрчим хүчний хэмнэлт төсөл”	Азийн хөгжлийн банкны зээл	1,811,683.8 USD, (2%)	91,924,918.77	1998-2031	1998-2001	Төслөөр компанийн хэмжээнд 110, 220 кВ-ын 43 дэд станцуудад квантун -77ш, вектрон-46ш, 35-220 кВ-ын гүйдлийн трансформатор /0,2s,0,5s/ 270ш, 35 кВ-ын хүчдлийн трансформатор 16ш тус тус суурилуулж ашиглалтад оруулсан. Мөн тоолуурыг шалгаж баталгаажуулах зориулалттай орчин үеийн технологи бүхий тоолуур 4ш, тоолуур шалгах төхөөрөмж РҮС5050 4ш нийлүүлэгдэж суурилагдсан. Энэхүү төслөөр дэд станцуудын насжилт өндөртэй хуучин тоног төхөөрөмжүүдийг шинэчилж сайжруулсанаар ашиглалтын түвшин дээшилж, эрчим хүчийг алдагдал багатай дамжуулах нөхцлийг бүрдүүлж өгсөн.
2	“Эрчим хүчний хөтөлбөр-1”	ХБНГУ-ын Засгийн газар, KFW банкны зээл	2,739,923.7 2 USD, (1.75%)	156,597,059.57	2003-2036	2004-2006	Дамжуулах сүлжээний нэгдсэн систем үүсгэгч 220/110 кВ-ын 13 дэд станцуудад диспетчерийн хяналт, удирдлагын системийг /SCADA/ байгуулсан. Мэдээллийг цаг тухайд оновчтой дамжуулах, хүлээн авах, хяналтын системийн тойрог үүсгэгч 110 кВ-ын ЦДАШ-ын аянгын троссыг шилэн кабель бүхий аянгын троссоор солих, хуурай салгуурын блоккон тактуудыг бүрэн шинэчилсэн. Мөн Ил хуваарилах байгууламж 4,3 болон 110 кВ-ын 17 дэд станцын 27 ком тосон таслуурыг орчин үеийн элегаз таслуураар шинэчилж, 81 ком нарийвчлал сайтай гүйдлийн трансформаторыг шинээр суурилуулж, хоёрдогч хэлхээний кабелиудыг шинэчилсэн. Эрчим хүчний системийн баланс сайжирч, зүй бус алдагдал эрсб агассан, мэдээллийг түргэн шуурхай авах шинэ технологи бүхий диспетчерийн хяналт мэдээллийн системийг шинээр үүсгэсэн. Хуучирсан тоноглолуудыг шинэчилсэнээр ашиглалтын ажиллагаа сайжирч, тасралт, гэмтлийн тоо буурч, эрчим хүчий үр ашигтай, найдвартай дамжуулах нөхцөл бололцоог бүрдүүлж өгсөн.

	“Эрчим хүчний хөтөлбөр-2” төслийн нэмэлт гэрээний төсөл.	ХБНГУ-ын Засгийн газар, KFW банкны зээл	4,156,242.9 USD, (1.75%)	260,173,703.61	2007-2036	2007-2008	Дарханы дулааны цахилгаан станцын 110 кВ-ын ХХБ-ийн 40 гаруй жил ашиглагдсан ашиглалтын хугацаа дууссан, насжилт өндөртэй хуучин тоноглолуудыг буулгаж, 110 кВ-ынтаслуурууд, 110 кВ-ынхуурай салгуурууд, 110 кВ-ын гүйдлийн болон хүчдлийн трансформаторууд, реле хамгаалалт автоматикийн байгууламжийг бүрэн сольж шинэчилсэн. Хуучин тоноглолуудыг шинэчилснээр ашиглалтын түвшин дээжилж, цахилгаан эрчим хүч дамжуулах найдвартай ажиллагаа эрс сайжирсан болно.
3	"Төвийн эрчим хүчний системийн дамжуулах сүлжээг шинэчлэн, засварлах төсөл" Шведийн /SIDA/	Шведийн олон улсын хөгжлийн агентлагын буцалтгүй тусламж болон хүүгүй зээл	*Төслийн нийт төсөвт өртөг – 80 сая швед крон Үүнээс: *Буцалтгүй тусламжийн төсөв төртөг – 57,8 сая швед крон *Хүүгүй зээлийн хэмжээ – 22,2 сая швед крон	42,054,668.41	2012-2036	2006-2010	220/110 кВ-ын ИХБ-4, 220/110/35 кВ-ын Дархан дэд станц, Эрдэнэт дэд станц, Багануур дэд станц, Чойр дэд станц гэх мэт 220, 110 кВ-ын 15 дэд станцуудын нийт 76ш тосон таслуур, 34 комгүйдлийн трансформатор, 8ш хүчдлийн трансформатор, хуурай салгуур (ОД, КЗ) 22ш, 35 кВ-ын 10 МВА-гийн реактор 1ш, 35 кВ-ын хуурай салгуур 2ш, реле хамгаалалт автоматикийн 10ш панелийг шинэчлэх барилга угсралт, суурилуулалтын ажил хийгдсэн.Төслөөр шинэ техник, технологи бүхий тоног төхөөрөмжийг суурилуулсанаа рдэдстанцуудын ашиглалт болон 220, 110, 35 кВ-ын ЦДАШ-ын дамжуулалтын найдвартай ажиллагаа сайжирч, тасралт, гэмтлийн тоо буурч, эрчим хүчийг үр ашигтай, найдвартай дамжуулах нөхцөл бололцоог бүрдсэн. Мөн тосон таслуурыг элегаз таслуураар сольсоноор ашиглалтын зардал буурч, байгаль орчинд үзүүлэх хор хөнөөл, хүлэмжийн хийг багасгаж, байгаль орчинд ээлтэй тоног төхөөрөмж, технологи ашиглах эхний алхам болсон. Төслийн гүйцэтгэгч: Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК
4	"Шивээ-Овоогийн уурхайн техникийн шинэчлэл-2 төсөл"	Япон улсын ЗГ-ын зээлийн санхүүжилт	261,980,000 иен, (1.75%)	142,805,521.28	2012-2033	2012-2013	Шивээ овоогийн нүүрсний уурхайн цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хангах зорилготой энэхүү төслөөр Шивээ-Овоо 110/6 кВ-ын 6,3х2 МВА чадалтай дэд станц, 18 км урттай 110 кВ-ын ЦДАШ-ын барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Тус төсөл хэрэгжсэнээр Шивээ овоогийн нүүрсний уурхайн цахилгаан хангамжийн найдвартай, тасралтгүй ажиллагаа дээшилсэн болно.
5	“Монгол Улсад полихлорт бифенилий г байгаль орчинд ээлтэй аргаар устгах менежмент ийн чадавхыг	“Даян дэлхийн байгаль орчны сан”-ийн Буцалтгүй тусламжийн хөрөнгөөр МУ-ын БОАЖЯ, НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн	Буцалтгүй тусламжийн хэмжээ 1,389,418,014,10 төгрөг	-	-	2013-2017	-“ЦДҮС” ТӨХК нь өөрийн бааз суурь, ажиллах хүч дээр түшиглэн Полихлорт Бифенилийн бохирдлыг (ПХБ) цэвэрлэх төслийн нэгжийг байгуулж, Монгол улсын хэмжээнд цахилгаан эрчим хүчний тоноглолд агуулагдаж буй ПХБ-ыг байгаль орчинд хоргүй аргаар цэвэрлэх үйл ажиллагааг гардан гүйцэтгэсэн.Төслийн хүрээнд “ЦДҮС” ТӨХК нь 2017 оны 11-р сарын байдлаар нийт 131 тоноглолын 1002 тонн ПХБ-н бохирдолтой цахилгаан тоног төхөөрөмжийг цэвэрлэх хоргүйжүүлж, төслийн үндсэн зорилтыг биелүүлсэн. -Төслийн гүйцэтгэгч: Итали улсын Сей Маркони Технологи Компани, БОАЖЯ, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК

	бий болгох төсөл”	газартай хамтран хэрэгжүүлсэн				
6	“Улаанбаатар – Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих” төсөл	БНХАУ-ын Засгийн газраас Монгол улсын засгийн газарт олгож буй 1 тэрбум ам долларын хөнгөлттэй зээлийн эх үүсвэрээс 120.0 сая ам.доллар гарган санхүүжүүлсэн.	- Монгол Улсын Засгийн газар 5.95 сая ам.доллар - БНХАУ-ын ЭКСИМ банкны зээл – 113.04 сая ам.доллар	-	-	2017-2020
						<ul style="list-style-type: none"> - Төслийн хүрээнд шинээр 220/110/35 кВ-ын 2х63 МВА хүчин чадалтай “Мандалговь” дэд станцыг барьж дуусгасан бөгөөд “Тавантолгой”, “Оюутолгой” дэд станцуудыг 220/110/35 кВ-ын 2х125 МВА хүчин чадалтай болгож өргөтгөсөн. - Улаанбаатар – Мандалговийн чиглэлд 330 кВ-ын овортой 220 кВ-ын 249 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам барьж дуусгав. - Монгол Улсын Засгийн газраас дэмжиж төвийн эрчим хүчний системээс ихээхэн хэмжээний чадал дамжих техникийн боломж бүхий Улаанбаатар – Мандалговийн чиглэлийн 330 кВ-ын овортой 249 км цахилгаан дамжуулах агаарын шугам болон 220/110/35 кВ-ын 3 дэд станцуудыг барьж байгуулан ашиглалтад оруулах шийдвэр гаргасны дагуу төслийг амжилттай хэрэгжүүлж дууссан. Уг бүтээн байгуулалтын ажил хэрэгжсэнээр өмнөд бүсийн эрчим хүчний хангамж найвартай болох төдийгүй Оюутолгой, Цагаансуварга, Тавантолгой болон бусад уул уурхайн орд газруудыг дотоодын цахилгаан эрчим хүчээр хангах боломжийг бүрдүүлж Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнээс ойролцоогоор 500 МВт буюу жилд 4.38 тэрбум кВт.цаг цахилгаан эрчим хүчийг өмнийн говийн бүсэд дамжуулах боломжийг бүрдүүлэх ба Оюутолгой, Тавантолгой, Цагаансуварга зэрэг стратегийн томоохон орд газруудыг дотоодын эрчим хүчний эх үүсвэрээр хангах боломж бүрдсэн. - Монгол Улсад анх удаа хамгийн өндөр хүчин чадал бүхий 330 кВ-ын Улаанбаатар – Мандалговийн цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын “Мандал”дэд станц ашиглалтад орсноор 2 талын эх үүсвэртэй систем хоорондыг холбосон чухал ач холбогдолтой агаарын шугам болсон төдийгүй орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон дээрх зангилаа дэд станцууд нь эрчим хүчний системийн ашиглалтын аюулгүй найдвартай, ухаалаг ажиллагааг хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ. - Улаанбаатар-Мандалговийн цахилгаан дамжуулах агаарын шугам дэд станц барих төсөл ашиглалтад орсон даруйдаа Монгол Улсын нийгэм, эдийн засагт үр өгөөжөө өгч эхлэх ба хойд, урд хөрш орнуудад эрчим хүч экспортлох боломжтой болох төдийгүй өрнө, дорныг холбосон уртрагийн цахилгаан шугам сүлжээг үүсгэх эхлэл тавигдаж байгаа юм.
		Нийт		693,555,871.64		

Б. ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР АЖИЛЛАЖ БУЙ ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Д/д	Төслийн нэр	Төслийн санхүүжилт	Зээлийн хэмжээ, зээлийн хүү	Зээл төлөлтийн хэмжээ	Зээл төлөгдөх хугацаа	Төсөл хэрэгжих хугацаа	Төслөөр хэрэгжүүлэх ажил, явцын мэдээлэл
1	Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл	ХБНГУ-ын Засгийн газар, KFW банкны хөнгөлттэй зээл	20,450,000 евро (3,75%)	1,363,333.34 евро	2028-2048	2018-2021	<ul style="list-style-type: none"> - 220, 110 кВ-ын 30 гаруй дэд станцын насжилт өндөртэй, хуучирч муудсан, ашиглалтын хугацаа дууссан тосон тоноглолууд болон реле хамгаалалтыг шинэчлэх. - Зөвлөх үйлчилгээ шалгаруулах олон улсын тендерийг зарлаж, Герман улсын Integration компани шаргарч зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. - Анхдагч болон хоёрдогч хэлхээний эзэлхүүн гаргах ажил хийгдэж дууссан. - Гүйцэтгэгч шалгаруулах тендерийн баримт бичиг боловсруулж байна. - Бие даасан төслийн нэгж нь ЭХЯ-ны харьяанд ЦДҮС ТӨХК дээр байгуулагдсан.
2	Эрчим хүчний сүлжээнд ашиглах том хэмжээний хуримтлуурын төсөл	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл	100 сая ам доллар /2.75%/	287.375 ам.доллар	2025-2045	2020-2022	<ul style="list-style-type: none"> - 80 МВт /200 МВт.ц хүчин чадалтай хуримтлуурын станцыг барьж ашиглалтад оруулж, Эрчим хүчний системийн тогтвортой үйл ажиллагааг хангах. - Зөвлөх компани: ХБНГУ-н RWE technologies компани, туслан гүйцэтгэгч: Мон-Энержи Консалт ХХК. Төслийн гүйцэтгэгчийн олон улсын тендер зарласан бөгөөд ZTT компани шалгарч гэрээ байгуулсан. - Барилга угсралтын ажлын урьдчилсан бэлтгэл ажлууд хангагдсан. - Төслийн барилга угсралтын ажлын түүхий эд, бараа материал захиалга хийгдэж байна. - Ерөнхий болон нарийвчилсан төлөвлөлтийн зураг төслийн ажлууд хийгдэж байна. - Бие даасан төслийн нэгж нь ЭХЯ-ны харьяанд байгуулагдсан.
		Монгол улсын засгийн газар	11,95 сая ам.доллар				
		Японы технологи хөгжүүлэх сангийн буцалтгүй тусламж	3 сая ам доллар				

3	Чойр-Сайншандын чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, Сайншанд хотод 220 кВ-ын дэд станц барих төсөл	Европын сэргээн босголт хөгжлийн банкны хөнгөлттэй зээл	56.6 сая ам доллар	-	-	2020 оноос	<ul style="list-style-type: none"> - Чойр-Сайншанд чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам болон Сайншандад 220 кВ-ын дэд станц шинээр барьж ашиглалтад оруулах. - Хөрөнгө оруулагч тал төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийж дууссан ба хөрөнгө оруулалтыг эцэслэн шийдэх болон зөвлөх үйлчилгээний тендерийн бичиг баримтыг боловсруулах ажил хийгдэж байна. - Европын сэргээн босголт хөгжлийн банк болон Сангийн яам хооронд зээлийн хөрөнгийг баталгаажуулах тусгайлсан гэрээг байгуулсан. - Төслийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх 3 талт гэрээний төсөлд санал авч байна. - Бие даасан төслийн нэгжийг байгуулахаар ажиллаж байна.
4	Дэлхийн банкны хөнгөлттэй зээлээр хэрэгжиж буй Эрчим хүчний төсөл	Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээл	630,000 ам.доллар	-	-	2017 оноос	<ul style="list-style-type: none"> - Олон жил ашиглагдсан, засварын зардал өндөртэй 35 кВ-ын 10 иж бүрэн тосон таслуурыг реле хамгаалалтын хамт шинэчлэх - Дамжуулах сүлжээний реле хамгаалалт, автоматикийн ажиллагаа, тавил тооцоонд гадны экспертээр хөндлөнгийн техникийн дүгнэлт, аудит хийлгэх - Бие даасан төслийн нэгж нь ЭХЯ-ны харьяанд байгуулагдсан. - Төслийн гүйцэтгэгч: Алтай-Трейст ХХК, М-Сил ХХК

5	Улаанбаатар хотын “Их тойрог” төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “Их тойрог 110 кВ, 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих” төсөл	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар	-	-	-	2012 оноос	<ul style="list-style-type: none"> - 110/35 кВ-ын "Телевиз" дэд станц - 110/35/10 кВ-ын "14-р хороолол" дэд станц - 110/35/10 кВ-ын "7-р хороолол" дэд станц - 110/35/10 кВ-ын “Багахангай” дэд станц - 110/10 кВ-ын "Буянт-Ухаа" дэд станц - 110/35/10 кВ-ын "Зайсан" дэд станц - 110/35/10 кВ-ын “Залаат” дэд станц - 110/35/10 кВ-ын "Найрамдал" дэд станц - 110/35/10 кВ-ын "Шинэ яармаг" дэд станц <p>Дээрх 9 дэд станцыг угсарч, суурилуулж, тэдгээрийг холбосон 110 кВ-ын 2 хэлхээт 154,21 км ЦДАШ-ыг ашиглалтад оруулж, хүчдэлд залгах, Дэд станцуудын суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх</p>
---	---	-----------------------------------	---	---	---	------------	---

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭЛТЭС